



BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛТ ХК

**МОНГОЛ БАЗАЛТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

2019

❖ АГУУЛГА

- Мэндчигээ
- Хурлаар хэлэлцэх асуудал
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
- Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар хугацаа
- Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой төсөл
 1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
 2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох санал
- Хурлаас гарах тогтоолын төсөл
- Саналын хуудасны загвар

❖ МЭНДЧИЛГЭЭ

МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

“Монгол Базальт” ХК-ийн компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх, Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийн тухай асуудлуудыг хэлэлцэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчдэд хүргүүлж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-аар гаргасан дүгнэлтийг батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох
- Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх
- Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах

Хувьцаа эзэмшигч та бүхнийг 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын хурлын танхимд болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирэхийг урьж байна.

❖ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх

/ ТУЗ-ийн дарга Л.Ариунболд / 3 минут

2. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:

2.1 Компанийн жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт

/ ТУЗ-ийн дарга Л. Ариунболд / 10 минут

2.2 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга

/ Нэр дэвшүүлэх хорооны гишүүн А.Энхгэрэл/ 4 минут

2.3 ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай танилцуулах

/ Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл / 5 минут

2.4 Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх эсэх

/ Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл / 5 минут

2.5 Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төсөл

/ ТУЗ-ийн дарга Л.Ариунболд / 15 минут

3. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт , хариулт

3 минут

4. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл

3 минут

5. Саналын хуудсаар санал авах

10 минут

Үдийн цай

20 минут

6. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах

5 минут

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хурлын дарга танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хаах

5 минут

Хурлын үргэжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

❖ **ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ
БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ
БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР,
ХУГАЦАА**

Хувьцаа эзэмшигчид нь 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 11:00 – 16:00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэрын 7 давхарт ирж танилцаж болно.

*“Монгол базальт”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 3 сарын 4 өдрийн №2 тоот тогтоолын
Хавсралт № 1*

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ

БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн жагсаалтууд:
1	“Монгол Базальт”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар
2	Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичиг.Үүнд:
	1. “Монгол Базальт”ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
	2. Аудитын дүгнэлт
	3. Саналын хуудас
	4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоол шийдвэрийн төсөл
	5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал
	6. “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 3 сарын 4-ний өдрийн №4 тоот тогтоол “Ногдол ашгийг нэмэгдүүлэн хуваарилах тухай”

❖ МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Базалт ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2018 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Монгол Базалт ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Монгол Базалт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөг зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2018 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулах, түүхий эд материалын бэлтгэлийн ажлыг сайн зохион байгуулах, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах, бүтээгдэхүүний тоо хэмжээг төрөлжүүлэх, дотоод/гадаадын борлуулалтын сувгуудын тогтолцоог сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

Монгол Базалт ХК 2018 онд 3.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 142%, цэвэр ашиг 217 сая төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 637%-иар өссөн гүйцэтгэлтэй гарлаа. Түүхий эд бэлтгэл өмнөх 2017 оноос 34%-иар нэмэгдүүлж, нийт 3500 тонн түүхий эд бэлтгэсэн байна.

Монгол Базалт ХК тайлант хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж дээр 16,925,100 ширхэг хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгож нийт 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татан төвлөрүүлснээс 3.6 тэрбум төгрөг буюу 56.2%-ийг чулуун хөвөнгийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжүүдийн шинэчлэл өргөтгөл, үйлдвэрийн барилгын өргөтгөл, шинэчлэлт, үйлдвэрт ашиглах машин механизм болон бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна.

Мөн 2018 онд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалт болон ОХУ-н Уралын Политехникийн Их сургуультай эхлүүлсэн Эрдэм шинжилгээний ажлын эхний үр дүнд үйлдвэрлэлийн бүтээмжийг 20%-иар нэмэгдүүлэн цагт 1 тонн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг цагт 1.2 тонны гарцад хүргэсэн байна.

Иймд Монгол Базалт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

❖ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮНД:**

1. Шаравсамбуу ЭНХТӨР
2. Чансаа ЗОРИГТБААТАР
3. Түвшинтөр ЦЭНД-АЮУШ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД:

1. Лхагважав АРИУНБОЛД
2. Галбадрах ГАНЗОРИГ
3. Ариунболд ЭНХГЭРЭЛ
4. Пүрэвбанзрагч САЙНБИЛЭГ
5. Бадарч ШАРАВСАМБУУ
6. Ширэндэв БАТЖАРГАЛ
7. Хан Гю Бунг /Han Kyu Bong/

❖ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ
БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ
НАМТАР**



ШАРАВСАМБУУ ЭНХТӨР

Мэргэжил: Эрх зүйч, Банкны Удирдлага

Боловсрол:

1987-1992 он Хилийн Цэргийн Командын Дээд

Сургууль - Командын Офицер

1993-1997 он МУИС, Хууль Зүйн Их Сургууль -

Эрх Зүйч

2000-2004 он СЭЗИС- Банкны Удирдлага

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1997-2009 он Худалдаа Хөгжлийн Банк, Хуульч, Ахлах хуульч, Газар Хэлтсийн дарга
2009-2013 он Хадгаламж Банк- Газрын Захирал

2013 оноос одоог хүртэл Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын
холбоо- Өмгөөлөгч



ЧАНСАА ЗОРИГТБААТАР

Мэргэжил: Хуульч, Эдийн засагч

Боловсрол:

Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль- Банк,

Санхүүгийн Эдийн Засгийн Баклавр

МУИС, Хууль Зүйн Их Сургууль- Хууль Зүйн

Магистр, Эрх Зүйч

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1996-1997 он Төрийн Өмчийн Хороо- Хуулийн Зөвлөх

1997-1998 он Хууль Зүйн дунд Сургууль – Хичээлийн эрхлэгч

1998-2007 он Монгол Банк – Хуулийн хэлтэсийн мэргэжилтэн

2007-2008 он Зоос банк – Эрх зүйн газрын захирал

2008 он Лекс Коунсел ХХК- Гүйцэтгэх захирал



ТҮВШИНТӨРИЙН ЦЭНД-АЮУШ

Мэргэжил:

Бизнесийн удирдлага, Компанийн засаглалын
эксперт, Эдийн засагч

Боловсрол:

2000-2012 он МУИС- Бизнесийн Удирдлага

1998-1999 он МУИС- Эдийн засгийн ухааны
магистер

1988-1992 он МУИС- ЭЗФ, Үйлдвэрлэлийн
удирдлага ба эдийн засгийн бакалавр

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1993-2005 он СЭЗДС-ийн Багш

2006-2008 он Зөвлөгөө өгөх төвийг хариуцсан СЭЗДС-ийн дэд захирал

2007-2009 он Амжилтын хөтөч ТББ-ийн Гүйцэтгэх захирал

2009-2013 он КЗХТ-ийн ТУЗ-ийн Нарийн Бичгийн Дарга

2013 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн профессор

2016 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн КЗХТ-ийн хамтарсан Компанийн засаглалын
МВА-ийн хөтөлбөрийн эрхлэгч,

2014 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн ТУЗ-ийн нарийн Бичгийн дарга

2013 оноос одоог хүртэл КЗХТ-ийн Гүйцэтгэх захирал

❖ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН
ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ
НАМТАР**



ЛХАГВАЖАВ АРИУНБОЛД

Мэргэжил:

Цахиурын исэлд суурилагдсан эрдэсийн хайлах болон дулаанаар боловсруулах технологийн үйлдвэрийн инженер,
Эдийн Засагч

Боловсрол:

ЗХУ-ын Свердловскийн Уралын Политехникийн дээд сургуулийн “Силикатын технологи”-ийн факультет, АНУ-ын Колорада Эдийн засгийн их сургууль

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1987-1990 онд БЦУГ-ын Засвар механикийн заводад Ерөнхий механик, Ерөнхий инженер,

1990-1993 онд Автомашины салхины шилний Төслийн удирдагч, Төслийн үр дүнд Автомашины салхины шилний үйлдвэр “Чин” ХХК байгуулагдсан.

1999-2012 онд “Моншил” төслийн удирдагч, Төслийн үр дүнд Шилэн лонхны үйлдвэрийн төсөл

2005 оноос чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлагч, төслийн удирдагч,

2007 оноос “Монгол Базалт” компанийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал



ГАЛБАДРАХ ГАНЗОРИГ

Мэргэжил:

Цэргийн командлагч, Улс төр судлаач

Боловсрол:

1976-1980 Одессит ЦНДС

1990-1992 Улс төрийн их сургууль

2006-2008 БХИС-Удирдлагын академи

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1980-1984 Ардын армийн 138 дугаар ангид- Салааны захирагч

1984-1988 Ардын армийн 138 дугаар ангид- ЗАБ-ын ахлах офицер

1988-1992 Ардын армийн 138 дугаар ангид- Дайчилгаа эрхэлсэн штабын офицер

1992-1994 Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид- Штабын орлогч

1994-1997 Нийслэлийн Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэст-Шуурхай албаны офицер

1997-2008 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт-Тоо бүртгэл, нөхөн хангалтын офицер

2008-2011 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт- Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер

2011-2013 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт- Цэргийн штабын орлогч дарга

2016-оноос “Монгол Базалт” ХК Шугам хоолой дэд бүтэцийн дулаалгын төслийн багийн удирдагч



АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ

Мэргэжил:

Үйлдвэр Үйл ажиллагааны Менежмент, Санхүү
Менежмент

Боловсрол:

2014 – 2017 Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

2008 – 2011 Лондон Метрополитан Их Сургууль

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

2008 – 2011 Лондон, “ЛУКСОТИКА” компанийн Кингстон салбарын Менежер

2011 - 2012 “Мянганы Сорилтын Сан” – Crown Agents- Худалдан Авах Газрын
Менежер

2013 – 2017 “Монгол Базальт” ХК Олон улсын төсөл хариуцсан Захирал

2017 – 2018 “Монгол Базальт” ХК –н ТУЗ-н гишүүн, Үнэт Цаас Хариуцсан
мэргэжилтэн

2018 – оноос “Монгол Базальт”ХК-н Гүйцэтгэх Захирал



ПҮРЭВБАНЗРАГЧ САЙНБИЛЭГ

Мэргэжил: Технологийн Инженер, Санхүүч

Боловсрол:

ПТДэд сургууль- Технологийн Инженер

СЭДС- Банк зээлийн эдийн засагч –Санхүүч

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1995-2000 он Сайн Сан ХХК- Захирал

2000-2007 он Жи Ви Эн ХХК- Гүйцэтгэх Захирал

2007- оноос “Монгол Базальт” ХК Санхүү

Хариуцсан захирал



БАДАРЧ ШАРАВСАМБУУ

Мэргэжил:

Нягтлан бодогч, Гавъяат Эдийн засагч

Боловсрол:

1965-Улаанбаатар худалдааны Техникум-

1975- Улс Ардын Аж Ахуйн Дээд Сургууль-

Москва хотын Маркетинг, Эрэлт Судлалын хүрээлэнгийн Эрдмийн Зэрэг Хамгаалах зөвлөлд- Монголын Хэрэглэгчийн Зах Зээлийн Өөрчлөн байгуулалтын асуудлаар PhD Доктор цол, Эдийн Засгийн Ухааны Доктор

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1965-1970 он Толгойт төв бараа бааз- Тооцооны ахлах орлогч Нябо

1975-1979 он Худалдаа Бэлтгэлийн Яам- Ахлах Мэргэжилтэн, газрын дарга

1979-1984 он Худалдаа Бэлтгэлийн Яам- Орлогч Сайд

1984-1990 он Худалдаа Бэлтгэлийн Яам- Сайд

1990-он Сайд нарын Зөвлөлийн - Орлогч Дарга

1991-1994 он Москва-д Суугаа ЭСЯ-1-р Нарийн Бичгийн Дарга

1994-1996 он Гаалийн Ерөнхий Газар- Дарга

1996-1998он Улаанбаатар Импекс Компани- ТӨ УҮГ- Ерөнхий захирал

1996-2000 он Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль- Маркетингийн Тэнхимийн Эрхлэгч

2000-2004 он Улсын Их Хурлын Гишүүн

2005-2011 он Санхүүгийн Зохицуулах Хороо- Орон тооны Гишүүн, Дэд дарга



ШИРЭНДЭВ БАТЖАРГАЛ

Мэргэжил:

Нягтлан Бодогч, Компанийн Засаглалын мастер

Боловсрол:

2006-2010 он СЭЗИС – Нягтлан бодогч

2016-2017 он СЭЗИС- Компанийн засаглал

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

2006-2007 он SEAMARK- Бизнес зөвлөх, компанийн судалгааны мэргэжилтэн

2009-2010 он Golden home- Ерөнхий нягтлан бодогч

2010 он Big Bridge- Үйлдвэр хариуцсан менежер

2007 он- одоог хүртэл Бутбат-Алтай- Гүйцэтгэх Захирал, Брокер, Дилер, ТУЗ-н дарга

2011 он ХҮННҮ МЕНЕЖМЕНТ” ХК- ТУЗ-н дарга

2012 он “Е-МОНИЕ” ХК- ТУЗ-н дарга

2014 он “ДОРНОД ТЭЭВЭР” ХК- ТУЗ-н дарга



HAN KYU BONG /ХАН ГЮ БУНГ/

Мэргэжил:

Бизнес удирдлагын мастер

Боловсрол:

1981-1985 БНӨСҮ-н Их Сургууль –Бизнес
Удирдлагын Баклавар

2007 БНӨСҮ-н Их Сургууль – Бизнес
удирдлагын Мастер

Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1999-2006 Hyundai, салбарын дарга,

2006- 2013 Гаули Инвестмент, гүйцэтгэх захирал,

2013- хойш Гаули ҮЦК, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрбээр үнэт цаасны зах зээл дээр нийт 32 жил ажилласан туршлагатай бөгөөд БНӨСҮ-ын ҮЦЗЗ дээр 2,3 их наяд вонын хөрөнгийг татан төвлөрүүлсэн, МУ-ын ҮЦЗЗ дээр 127 тэрбум төгрөгийг санхүүжилтийг татан төвлөрүүлсэн байна.

❖ **ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН
УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ САНАЛ:**

ТУЗ-ын гишүүдийн цалин		Шинэчлэх санал / төг/
Тогтмол цалин	Үндсэн	400 000₮
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200 000₮
	Хорооны даргын нэмэгдэл	100 000₮
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд ололцсон тоогоор	100 000₮
Сарын дундаж цалин	ТУЗ-ийн гишүүд	
	Нийт/ 9 гишүүний/	

Хурлууд	Хурлын тоо
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Жилд 1 удаа
ТУЗ-ийн ээлжит хурал	Жилд 6 удаа
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл,аудитын хорооны ээлжит хурал	Жилд 4 удаа
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурал	Жилд 2 удаа
ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны ээлжит хурал	Жилд 2 удаа

❖ **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ГАРАХ
ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 1

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11 заалт, “Монгол Базалт” хувьцаат компанийн 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базалт” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 2

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9 дэх заалт, компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. “Монгол Базалт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

1. овогтой
2. овогтой
3. овогтой
4. овогтой
5. овогтой
6. овогтой

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1. овогтой
2. овогтой
3. овогтой нарыг
тус тус сонгосугай.

ХОЁР. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм, дотоод журмуудад заасан үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 3

Улаанбаатар хот

***Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин,
урамшууллын хэмжээг тогтоох тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.15 дах заалт, компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базалт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг хавсралт 2-оор баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сар бүрт нь тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

А.ЭНХГЭРЭЛ

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 4

Улаанбаатар хот

Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.14 дэх заалт, компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу “Монгол Базалт” ХК нь өөрийн гаргасан энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн эргүүлэн худалдаж авах нөхцөл, хувь хэмжээ, үнэ, эргүүлэн худалдан авах журмыг боловсруулж батлах, үнэт цаасыг эргүүлэн худалдан авахтай холбогдсон шийдвэр гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
3. Компани өөрийн гаргасан хувьцаагаа эргүүлэн авсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж байхыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА :

А.ЭНХГЭРЭЛ

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 5

Улаанбаатар хот

***Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх,
техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах***

Компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базалыт” ХК-ийн үйлдвэрийн хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг хавралт 3-аар баталсугай.
2. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг хариуцан гүйцэтгэх, хувьцаа эзэмшигчдийг мэдээлэл хүргэх, танилцуулах үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА :

А.ЭНХГЭРЭЛ

МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИ

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 3 сарын 4-ний өдрийн 2. тоот тогтоолын Хавсралт № 1

“Монгол Базальт” ХК- ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын

САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах			
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай			
3	Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх			
4	Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах			

(Та саналыг хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигчГарын үсэг Брокер Гарын үсэг

/ тэмдэг /

2019 оны сар.....өдөр

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК)дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаарх мэдээллийг 99010166 утсаар лавлаж болно.
- Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан /Доор бичнэ үү./
Тооллогын комиссын дарга.....
Тооллогын комиссын гишүүн.....

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 3 сарын 4-ний өдрийн 2. тоот тогтоолын Хавсралт № 2

“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын

САНАЛ АВАХ ХҮУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Кумулятив саналын тоо.....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани /

Брокерийн овог нэр

“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын хурлын танхимд болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
Ердийн гишүүд:		
1	Л.Ариунболд	
2	Г.Ганзориг	
3	А.Энхгэрэл	
4	П.Сайнбилэг	
5	Ш.Батжаргал	
6	Б.Шаравсамбуу	
7	Han Kyu Bong /Хан Гю Бунг/	
Хараат бус гишүүд:		
1	Ш.Энхтөр	
2	Ч.Зоригтбаатар	
3	Т.Цэнд-Аюуш	

Хувьцаа эзэмшигчГарын үсэг Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

2019 оны сар..... өдөр

Саналын хуудас бөглөх санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятиваар аргаар таны санал өгөх эрхийн нийт тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан.....

Тооллогын комиссын дарга.....

Тооллогын комиссын гишүүн.....

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.



"Фламинго Тауэр" 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот, Монгол улс



7511-4444



www.rockwool.mn



monbasalt@rockwool.mn



Mongol Basalt JSC



@Mongol_Basalt



Mongol_Basalt